



Хаяг: Улаанбаатар 16052, Баянгол дүүрэг, Энхтайвны өргөн чөлөө,  
УБ Платинум барилга, 5-р давхар  
Утас: 70115577, 70115151, Факс: 70118501  
И-мэйл: sales@globaltelecom.mn, Вэбсайт: www.globaltelecom.mn

## Глобал Телеком ХХК

Улаанбаатар хот

№ GT19/  
/290

2019 он 10 сар 2 өдөр

### ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ АЛБА-д

Тендерийн тодруулга авах тухай

Манай Глобал Телеком ХХК нь Чингэлтэй дүүргийн худалдан авах ажиллагааны албанаас зарласан “Хорооны нутаг дэвсгэрт камержуулалт хийх /11, 13, 14, 15, 16, 17 18-р хороод/” ЧДХААА/201901010 тоот тендер болон “Камержуулалт /ЧД 18 дугаар хороо/ “НХААГ/201901248 тоот тендерийн талаар дараах тодруулгыг авах хүсэлтэй байна.


Уг хоёр тендерийн баримт бичигт Чингэлтэй дүүргийн 18-р хороог камержуулах ажил тусгагдсан байгаа бөгөөд тоног төхөөрөмжүүдийн тоо хэмжээ болон ажил гүйцэтгэх цэгүүд яг ижил байна.

1. “Камержуулалт /ЧД 18 дугаар хороо/ “НХААГ/201901248 тоот тендерт туслаа 18-р хороог камержуулах ажил тусгагдсан байгаа тул “Хорооны нутаг дэвсгэрт камержуулалт хийх /11, 13, 14, 15, 16, 17, 18-р хороод/” ЧДХААА/201901010 тоот тендерт 18-р хороо байх шаардлагатай юу?
2. ЧДХААА/201901010 тоот тендерээс 18-р хороог уг ажлын хүрэнээс хасаад төсөн тооцоолж бид үнийн саналт явуулж болох уу?

Үүн дээр бидэнд тодруулгын харнууг яаралтай гаргаж өгнө үү.

Хүндэтгэсэн,



  
А. АЗЖАРГАЛ



**НИЙСЛЭЛИЙН ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРЭГ  
ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ  
АЛБА**

Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газрын байр,  
Ж.Самбуугийн гудамж, 4 дүгээр хороо, Чингэлтэй дүүрэг,  
Улаанбаатар хот, 15170  
Утас: 7011-0769, Факс: (976-11) 32-85-58  
E-mail: procurement@chingeltei.gov.mn  
http://www.chingeltei.gov.mn

2019.10.07 № 260  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-г

**Тодруулгын хариу хүргүүлэх  
тухай**

Танай байгууллагаас 2019 оны 10 дугаар сарын 02-ны өдөр Чингэлтэй дүүргийн Худалдан авах ажиллагааны албанд ирүүлсэн №GT19/20 дугаартай албан бичигтэй танилцлаа.

Тус албанаас зарласан “Камержуулалт /ЧД 18 дугаар хороо/” НХААГ/201901248, “Хорооны нутаг дэвсгэрт камержуулалт хийх /11, 13, 14, 15, 16, 17, 18 дугаар хороод/” ЧДХААА/201901010 дугаартай ажлуудын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерт “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийн 22 дугаар зүйлийн 22.3 дахь хэсгийн дагуу гаргасан тодруулгын хариуг хуулийн 22.4 дэх хэсгийн дагуу хүргүүлж байна.


“Камержуулалт /ЧД 18 дугаар хороо/” НХААГ/201901248, “Хорооны нутаг дэвсгэрт камержуулалт хийх /11, 13, 14, 15, 16, 17, 18 дугаар хороод/” ЧДХААА/201901010 дугаартай ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн баримт бичгийн ажлын зургийг, зураг төслийн “Арбэл Алтай” ХХК-р гүйцэтгүүлж захиалагч дүүргийн Засаг даргын Тамгын газраас Худалдан авах ажиллагааны албанд ирүүлсэн.

1. “Камержуулалт /ЧД 18 дугаар хороо/” НХААГ/201901248, “Хорооны нутаг дэвсгэрт камержуулалт хийх /11, 13, 14, 15, 16, 17, 18 дугаар хороод/” ЧДХААА/201901010 дугаартай 2 тендер шалгаруулалтад тус бүрт нь Чингэлтэй дүүргийн 18 дугаар хороо багтсан бөгөөд ажлын зургийг нийлүүлж гүйцэтгэсэн болно. Иймд “Хорооны нутаг дэвсгэрт камержуулалт хийх /11, 13, 14, 15, 16, 17, 18 дугаар хороод/” ажилд 18 дугаар хорооны ажлыг хасч тооцохгүй болно.
2. “Камержуулалт /ЧД 18 дугаар хороо/” НХААГ/201901248, “Хорооны нутаг дэвсгэрт камержуулалт хийх /11, 13, 14, 15, 16, 17, 18 дугаар хороод/” ЧДХААА/201901010 дугаартай тус 2 ажил нь 2 санхүүжилтын эх үүсвэрээр

2 тусдаа ажил тул сонирхогч аж ахуйн нэгжүүд тендерийн баримт бичигт тусгагдсан ажлын тоо хэмжээний дагуу үнийн санал ирүүлнэ.

Захиалагч дүүргийн Засаг даргын Тамгын газраас ирүүлсэн Чингэлтэй дүүргийн 18 дугаар хорооны нутаг дэвсгэрт камержуулалт хийх ажлын, ажлын зургийн заагийг тодорхойлсон зургийг хавсаргав.

ДАРГА

A square official stamp with a decorative border. Inside the stamp, there is a handwritten signature in dark ink. The signature is stylized and appears to be 'С. Жамъяндорж'. The stamp also contains some faint, illegible text, likely the name of the agency or the date.

С. ЖАМЪЯНДОРЖ